



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/278

Улаанбаатар хот

Түр заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, Улсын онцгой комиссын 02, 07 дугаар хуралдааны тэмдэглэл, 2020 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 02 тогтоол, Улсын онцгой комиссын даргын баталсан. "Тусгаарлан ажиглах, ажиглах түр журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-ын тусгаарлан ажиглалтад байгаа хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх түр зааврыг нэгдүгээр, тусгаарлан ажиглах байрны мэдээний хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Коронавируст халдвар (COVID-19)-ын тусгаарлан ажиглах үйл ажиллагааг холбогдох журам, зааварт нийцүүлэн зохион байгуулж, мөрдөн ажиллахыг тусгаарлан ажиглах ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллага, аж ахуй нэгжийн дарга, захирал нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, тусгаарлан ажиглах байранд дайчлан ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хуваарилах, дадлагажуулах сургалт зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа), төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буянжаргал) үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

141200967

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 05  
дугаар сарын 01 өдрийн 11/20 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## **КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН ТУСГААРЛАН АЖИГЛАЛТАД БАЙГАА ХҮНД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТҮР ЗААВАР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Коронавируст халдвар (COVID-19)-ын үед тусгаарлан ажиглах үйл ажиллагаа, тусгаарлан ажиглалтад байгаа иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх харилцааг энэхүү түр журмаар зохицуулна.

1.2. Тусгаарлан ажиглах байранд коронавируст халдвар (COVID-19)-ын тандалт сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, халдварын сэргийлэлт, хяналт, сэтгэлзүйн чиглэлээр сургалтад хамрагдсан төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эмч ахалсан, эмнэлгийн мэргэжилтэн, дадлагажигч эмчийн бүрэлдэхүүнтэй багийг томилон ажиллуулна.

### **Хоёр. Иргэнийг тусгаарлан ажиглалтад авах**

2.1. Тусгаарлан ажиглалтад авах иргэдийн талаар Улсын онцгой комиссын Шуурхай штабаас авсан мэдээлэлд үндэслэн бэлэн байдлыг хангана.

2.2. Иргэдийг тусгаарлан ажиглах байранд “Нэг хүн”, Нэг гэр бүл”, “Иргэн ба асран хамгаалагч” гэсэн зарчмыг баримтлан эмчийн хяналтад 21 хоног тусгаарлан ажиглана.

2.3. Коронавируст халдвар (COVID-19)-аар өвчлөөд эдгэрсэн хүнийг ажиглалтын байранд 14 хоног тусгаарлан ажиглана.

### **Гурав. Тусгаарлан ажиглалтад байгаа иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх**

3.1. Иргэн тусгаарлах байранд ирсэн даруйд эрүүл мэндийн байдлыг ажиглах Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Ажиглалтын хуудас”-ыг бөглөх зөвлөмжийг өгнө.

3.2. Тусгаарлан ажиглах байрны эмч иргэний халууныг өдөрт 2-оос доошгүй удаа зайнаас хэмжиж, тэмдэглэл хөтлөн, эрүүл мэндийн байдалд хяналт тавих ба иргэнд коронавируст халдварын сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирсон шинж тэмдэг илэрвэл нийслэлд ХӨСҮТ-ийн 100, 80086829 дугаарын утсанд, орон нутагт харьяа эрүүл мэндийн байгууллагад хандан мэдэгдэнэ.

3.3. Ажиглалтад байгаа иргэнд ямар нэгэн зовиур илэрвэл тусгаарлах байрны эмч анхан шатны үзлэг хийж, зөвлөгөө өгнө. Хэрэв төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай гэж үзвэл Эрүүл мэндийн яамны 323002 утсанд залгаж мэдээллийг өгч, лавлагаа төвүүдтэй холбогдоно.

3.4. Эрүүл мэндийн яамны 323002 утсан дээрх хариуцлагатай жижүүр нь төрөлжсөн мэргэжлийн эмчийг тусгаарлах байрны эмчтэй утсаар холбож өгнө.

3.5. Орон нутагт тусгаарлан ажиглалтад байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь тухайн аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч даргад мэдээллийг өгнө.

3.6. Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга тусгаарлан ажиглалтад байгаа хүнд зөвлөгөө өгөх, үзлэг хийх эмч, мэргэжилтнийг томилно.

3.7. Төрөлжсөн мэргэжлийн төв болон нэгдсэн эмнэлгийн томилогдсон эмч нь мэдээллийг авч, утсаар зөвлөгөө өгнө. Шаардлагатай тохиолдолд халдварын сэргийлэлтийн зааврыг баримтлан тусгаарлах байранд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.


3.8. Тусгаарлалтад байгаа иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг эмнэлгийн нөхцөлд үзүүлэх зайлшгүй шаардлагатай бол орон нутагт Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт, нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төв болон тусгайлан бэлтгэсэн эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж хэвтүүлэн эмчилнэ.

#### **Дөрөв. Мэдээллийн урсгал**

4.1 Тусгаарлан ажиглах байрны эмч ажиглалтад байгаа иргэдийн эрүүл мэндийн мэдээллийг энэхүү тушаалын 2 дугаар хавсралтын хүснэгтийн дагуу өдөр бүрийн өглөөний 9.30 цагт Эрүүл мэндийн хөгжлийн төвийн eekhemee\_0323@ yahoo.com хаягаар мэдээллийг өгнө.

4.2 Тусгаарлан ажиглалтаас гарч буй иргэдийн мэдээлэл (иргэний овог, нэр, регистр, холбоо барих 1-3 утасны дугаар, ажиглалтаас гараад тусгаарлагдах хаяг)-ийг Улсын онцгой комиссын шуурхай багт ажиглалт дуусахаас 48 цагийн өмнө мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 05  
дугаар сарын 01 өдрийн А/ дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



ТУСГААРЛАН АЖИГЛАХ БАЙРНЫ МЭДЭЭНИЙ ХУУДАС

Тусгаарлан ажиглах байрны нэр..... он сар өдөр

Мэдээлэл	Тоон мэдээлэл	Тайлбар
Тусгаарлан ажиглалтад байгаа нийт хүний тоо		
0-5 насны хүүхэд		
Жирэмсэн		
Чихрийн шижинтэй		
Артерийн даралт ихтэй		
Хавдар		
Бусад архаг өвчтэй		
Бусад архаг өвчтэйг үгээр задалж тодруулж бичих		
Зовиуртай хүний тоо		
Зовиуртай хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн мэдээлэл		
Тусгаарлан ажиглалтаас гарсан хүний тоо		
Лабораторийн шинжилгээ өгсөн хүний тоо		
Хамгаалах хэрэгслэл хангалттай /Гийм, үгүй/		
Ажиллаж байгаа эмч, дадлагажигч эмчийн тоо		
Ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтны тоо		

Төрөлжсөн/ үндсэн мэргэшлийн тусламж авсан тухай мэдээлэл:

---

---

---

---

---